



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахир сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/084/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэбулган хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalbaat@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2026-02-25 № 126
танай _____-ны № _____-т

ЦАХИР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Б.ХҮЧНЭМЭХ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 5232 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний 66,314.9 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,183,039.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,168,547.1 мянган төгрөгийг зарцуулан 14,492.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.Тайлант онд урсгал зардлаас 19,819.7 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн яамнаас 3,499.1 мянган төгрөгийн, нийт 23,318.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 19,100.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсөв захирагчаас 90.8 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>267,261,281.88</u>	<u>249,186,236.69</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,776,202.17	14,492,365.29
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,776,202.17	14,492,365.29
3121	Төгрөг	7,776,202.17	14,492,365.29
31211	Төрийн сангийн харилцах	7,776,202.17	14,492,365.29
33	АВЛАГА	105,296,811.66	66,314,982.43
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	105,296,811.66	66,314,982.43
35	БАРАА МАТЕРИАЛ	154,188,268.05	168,378,888.97
351	Түүхий эд материал	100,100,885.55	101,249,434.47
35110	Тусгай зориулалттай материал	61,423,098.25	63,254,557.79
35130	Эм боох материал	38,677,787.30	37,994,876.68
354	Хангамжийн материал	54,087,382.50	67,129,454.50
35410	Бичиг хэргийн материал	447,300.00	686,300.00
35420	Аж ахуйн материал	32,745,162.50	36,856,012.50
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,820,000.00
35440	Түлш, шатах тослох материал	20,740,000.00	27,687,492.00
35460	Хүнсний материал	154,920.00	79,650.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,397,994,431.24</u>	<u>2,327,356,301.09</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,397,994,431.24	2,327,356,301.09
392	Биет хөрөнгө	2,379,576,431.24	2,308,938,301.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,219,410,893.18	2,219,410,893.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(98,652,978.75)	(154,285,166.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	124,229,556.00	124,229,556.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(51,813,234.71)	(69,502,464.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	263,509,161.15	285,208,161.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(109,147,843.25)	(126,443,355.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,717,058.00	43,336,858.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,676,180.38)	(13,016,180.34)
393	Биет бус хөрөнгө	18,418,000.00	18,418,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.00)	(450,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,368,000.00	17,368,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,665,255,713.12</u>	<u>2,576,542,537.78</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,659,865,923.12</u>	<u>2,576,542,537.78</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,659,865,923.12	2,576,542,537.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		238,315,520.04	238,315,520.04
51101	Өмч: - төрийн	238,315,520.04	238,315,520.04
512	Хуримтлагдсан үр дүн	2,303,649,554.28	2,220,326,168.94
51210	Өмнөх үеийн үр дүн	2,303,649,554.28	2,303,649,554.28
51220	Тайлант үеийн үр дүн	-	(83,323,385.34)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,900,848.80	117,900,848.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,664,055,713.12</u>	<u>2,576,542,537.78</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,020,970,746.28	1,119,726,420.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,500,000.00	80,443,128.49
120	Нийтлэг татварын бус орлого	63,500,000.00	80,443,128.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	63,500,000.00	80,443,128.49
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,500,000.00	57,843,865.00
120017	Үнэ төлбөргүй БМ		19,100,163.49
120018	Үнэ төлбөргүй ҮХ		3,499,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	957,470,746.28	1,039,283,292.10
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,922,000.00	68,322,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,922,000.00	68,322,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	894,548,746.28	970,961,292.10
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	894,548,746.28	970,961,292.10
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	950,699,743.58	1,203,049,805.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	950,699,743.58	1,203,049,805.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	940,749,616.58	1,126,415,111.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	621,274,781.15	756,436,806.76
210101	Үндсэн цалин	360,715,301.19	364,048,296.27
210102	Нэмэгдэл	193,162,903.19	305,784,007.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,118,000.00	7,968,000.00
210104	Урамшуулал	63,278,576.77	78,636,502.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,025,200.00	95,014,888.20
210201	Тэтгэврийн даатгал	63,514,700.00	66,996,291.27
210202	Тэтгэмжийн даатгал	5,377,600.00	7,043,336.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,688,800.00	3,588,624.71
210204	Ажилгүйдлийн даатгал	2,688,800.00	3,473,227.04
210205	Эрүүл мэндийн даатгал	10,755,300.00	13,913,408.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,644,373.00	40,252,080.00
210301	Гэрэл, цахилгаан	9,932,373.00	13,139,562.00
210302	Түлш, халаалт	30,712,000.00	27,112,518.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,306,610.00	41,617,709.00
210401	Бичиг хэрэг	3,748,600.00	3,324,000.00
210402	Тээвэр, шатахуун	30,708,910.00	30,196,990.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,526,000.00	1,034,419.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,083,100.00	6,822,300.00
2105	Нормативт зардал	82,173,467.02	76,814,259.57
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,668,424.02	67,011,279.57
210502	Хоол, хүнс	8,538,043.00	9,802,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,303,460.00	5,361,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,991,960.00	1,437,000.00
210602	Тавилга	-	385,000.00
210604	Урсгал засвар	6,311,500.00	3,539,400.00
2107	Томилолт, зочны зардал	14,000,000.00	10,420,000.00

210702	Дотоод албан томилолт	14,000,000.00	10,420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,800,000.00	5,158,438.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,054,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,700,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	67,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	536,038.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,221,725.41	95,339,530.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	905,800.00	1,382,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,315,925.41	93,956,930.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,950,127.00	76,634,694.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	59,691,666.25
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,177,666.25
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	35,742,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,772,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,950,127.00	16,943,028.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,950,127.00	16,943,028.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	70,271,002.70	(83,323,385.34)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	70,271,002.70	(83,323,385.34)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	930,630,227.62	1,136,108,986.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,500,000.00	57,843,865.00
120	Нийтлэг татварын бус орлого	63,500,000.00	57,843,865.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	63,500,000.00	57,843,865.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,500,000.00	57,843,865.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	867,130,227.62	1,078,265,121.33
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,922,000.00	68,322,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,922,000.00	68,322,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	804,208,227.62	1,009,943,121.33
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	804,208,227.62	1,009,943,121.33
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	876,429,281.95	1,109,573,123.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	876,429,281.95	1,109,573,123.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	866,479,154.95	1,032,938,428.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	621,274,781.15	760,662,534.11
210101	Үндсэн цалин	360,715,301.19	364,048,296.27
210102	Нэмэгдэл	193,162,903.19	310,009,734.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,118,000.00	7,968,000.00

210104	Урамшуулал	63,278,576.77	78,636,502.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
		85,025,200.00	90,789,160.85
210201	Тэтгэврийн даатгал	63,514,700.00	62,770,563.92
210202	Тэтгэмжийн даатгал	5,377,600.00	7,043,336.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,688,800.00	3,588,624.71
210204	Ажилгүйдлийн даатгал	2,688,800.00	3,473,227.04
210205	Эрүүл мэндийн даатгал	10,755,300.00	13,913,408.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
		48,534,373.00	47,199,572.00
210301	Гэрэл, цахилгаан	9,932,373.00	13,139,562.00
210302	Түлш, халаалт	38,602,000.00	34,060,010.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
		41,005,610.00	43,370,559.00
210401	Бичиг хэрэг	3,117,400.00	3,538,000.00
210402	Тээвэр, шатахуун	30,100,910.00	29,600,990.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,526,000.00	3,597,269.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,021,300.00	6,394,300.00
2105	Нормативт зардал		
		48,845,690.80	62,477,165.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,463,530.80	50,629,455.00
210502	Хоол, хүнс	8,197,160.00	9,727,710.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,185,000.00	2,120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
		5,905,500.00	9,860,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,468,000.00	3,836,000.00
210604	Урсгал засвар	4,437,500.00	6,024,400.00
2107	Томилолт, зочны зардал		
		14,000,000.00	10,420,000.00
210702	Дотоод албан томилолт	14,000,000.00	10,420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
		600,000.00	6,608,438.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,304,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	2,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	67,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	536,038.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
		1,288,000.00	1,550,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,288,000.00	1,550,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,950,127.00	76,634,694.25
2132	Бусад урсгал шилжүүлэг		
		-	59,691,666.25
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,177,666.25
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	35,742,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,772,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
		9,950,127.00	16,943,028.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,950,127.00	16,943,028.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	54,200,945.67	26,535,863.12
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	58,576,805.00	19,819,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	58,576,805.00	19,819,700.00

2200	Дотоод эх үүсвэрээр	58,576,805.00	19,819,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	58,576,805.00	19,819,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(58,576,805.00)	(19,819,700.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(4,375,859.33)	6,716,163.12
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		7,776,202.17
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,776,202.17	14,492,365.29

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	2,303,649,554.28	2,659,865,923.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	2,303,649,554.28	2,659,865,923.12
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	2,303,649,554.28	2,659,865,923.12
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	2,303,649,554.28	2,659,865,923.12
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	2,303,649,554.28	2,659,865,923.12
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(83,323,385.34)	(83,323,385.34)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,315,520.04	117,900,848.80	2,220,326,168.94	2,576,542,537.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,251,361,600.00	1,112,449,795.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,251,361,600.00	1,112,449,795.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,182,652,900.00	1,052,758,128.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	818,044,600.00	760,662,534.11
210101	Үндсэн цалин	508,719,300.00	364,048,296.27
210102	Нэмэгдэл	223,258,300.00	310,009,734.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,555,200.00	7,968,000.00
210104	Урамшуулал	78,511,800.00	78,636,502.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,842,200.00	90,789,160.85
210201	Тэтгэврийн даатгал	71,521,300.00	62,770,563.92
210202	Тэтгэмжийн даатгал	8,330,300.00	7,043,336.93

210203	ҮОМШӨ-ний даатгал	4,165,100.00	3,588,624.71
210204	Ажилгүйдлийн даатгал	4,165,100.00	3,473,227.04
210205	Эрүүл мэндийн даатгал	16,660,400.00	13,913,408.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,322,200.00	47,199,572.00
210301	Гэрэл, цахилгаан	23,400,000.00	13,139,562.00
210302	Түлш, халаалт	38,602,200.00	34,060,010.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,356,100.00	43,370,559.00
210401	Бичиг хэрэг	3,808,900.00	3,538,000.00
210402	Тээвэр, шатахуун	32,000,000.00	29,600,990.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,616,100.00	3,597,269.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	431,100.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,500,000.00	6,394,300.00
2105	Нормативт зардал	77,720,100.00	62,477,165.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,698,100.00	50,629,455.00
210502	Хоол, хүнс	9,772,000.00	9,727,710.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,250,000.00	2,120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,033,800.00	29,680,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,533,800.00	23,655,700.00
210604	Урсгал засвар	8,500,000.00	6,024,400.00
2107	Томилолт, зочны зардал	17,900,000.00	10,420,000.00
210702	Дотоод албан томилолт	17,900,000.00	10,420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,950,000.00	6,608,438.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,000.00	3,304,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,750,000.00	2,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	67,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600,000.00	536,038.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,483,900.00	1,550,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,483,900.00	1,550,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,708,700.00	59,691,666.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,708,700.00	59,691,666.25
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,220,500.00	20,177,666.25
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	35,742,000.00	35,742,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,746,200.00	3,772,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,251,361,400.00	1,119,165,958.33
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	68,322,000.00	51,378,972.00
132001	Орон нутгийн төсвөөс	68,322,000.00	51,378,972.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,183,039,400.00	1,009,943,121.33
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,183,039,400.00	1,009,943,121.33
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	57,843,865.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	57,843,865.00

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		7,776,202.17
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		14,492,365.29
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулгын алдаа¹ илрээгүй.

Аудитаар залруулагдаагүй 7,859.2 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 2 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 7,859.2 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 10,502.8 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрчин, байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардал болох авто машины сэлбэг, бичиг хэрэг, аж ахуйн материал худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан 1,974.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, хоёрдугаар хавсралт “Зардлын эдийн засгийн ангилалын тайлбар”-т Хэрэглүүрийн гуравт “Төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана”, Төсвийн захирагчийн үүрэгт “Зардлын ангилалын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ”, 2103 -д” байр ашиглалттай холбоотой тогтмол зардалын тодорхойлолт”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо

5.1.2. Эмийн зарцуулалтад аудитын горим хэрэгжүүлэхэд хэвтэн эмчлүүлэгчдийн сторын цагийн тарианы түүвэр болон эм баригчын эмийн түүврийн нэгтгэлийн зарлага 4922 ш, санхүүгийн программын эм боох материалын цагийн тариа 5577 ш, эмийн захиалгаас 655 ширхэг буюу 687.0 мянган төгрөгийн эм боох материалыг анхан шатны баримтаас илүү зарлага бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” 8.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо

5.2 Албан шаардлага

5.2.1 Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүйтэй холбоотой 1,497.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно”, Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 01/103 албан тоотын заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох байх албан шаардлага хүргүүллээ.

5.2.2. Тайлант онд эм боох материалыг сумын эргэлтийн эмийн сан болон тендерт шалгараагүй аж ахуйн нэгжүүдээс худалдан авалт хийсэн, тендерийн үнэ, шалгуур үзүүлэлт баримтлаагүй, аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй холбоотой зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32.1-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.”, ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээ болон гэрээний хавсралтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох байх албан шаардлага хүргүүллээ

5.3 Зөвлөмж

5.3.1 Үндсэн хөрөнгө орлого авахдаа санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 3 нэр төрлийн 3,700.0 мянган төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дараа тайлангийн хугацаанд дээрх хөрөнгүүдийн элэгдлийг орлогод хүлээн авсан онуудаас эхлэн нөхөж тооцон холбогдох данс бүртгэлд залруулга хийх.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30

хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй	1	1,497.70			1	1,497.70		
Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл"нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй,	1	0.00			1	0.00		
Анхан шатны баримтгүй эм боох материал зарлага бүртгэсэн	1	687.0	1	687.0				
Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	1,974.50	1	1,974.50				
Санхүүгийн программд үндсэн хөрөнгө бүртгэхдээ ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 39 нэр төрлийн 42.5сая төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй,	1	3,700.0					1	3,700.0
Дүн	5	7,859.20	2	2661.5	2	1,497.70	1	3,700.0